



**2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН****ЦЭХ-ний боловсруулалт**


Компани 2022 онд 151.6 сая кВтц ЦЭХ боловсруулах төлөвлөгөөтэй байснаас гүйцэтгэлээр 157.8 сая ЦЭХ боловсруулж төлөвлөгөөг 4.09 сая кВтц-аар нэмэгдүүлж 102.7 %-иар биелүүлсэн байна.

**ЦЭХ –ний түгээлт:**


Тайлант хугацаанд 132.2 сая кВтц ЦЭХ түгээх төлөвлөгөөтэй байснаас 136.6 сая кВтц ЦЭХ түгээж 103.3%-ийн биелэлттэй гарсан.

**Дулааны эрчим хүчний талаар**

2022 онд усаар 195,834 Гкал, уураар 45306 Гкал, нийт 241,140 Гкал ДЭХ түгээсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 19,075 Гкал илүү түгээж төлөвлөгөөний биелэлт 108.6% байна. Дулааны түгээлтийн бүтцийг харуулбал: Нийт дулааны түгээлтийн 74.9 хувийг буюу 180,579 Гкал-ыг УБДС ХК, коллектороос 6.3 хувь буюу 15255 Гкал, уураар 18.8 хувь буюу 45,306 Гкал тус тус түгээсэн байна.



Дулааны эрчим хүчний түгээлтийн биелэлтийг сар бүрээр графикаар харуулбал:



**Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй, үр ашигтай зарцуулж ажиллах.**

**-Түлшний зардал:11,135.8**

**-Цалин, шимтгэлийн зардал:8,383.0**

**-Элэгдэл:2,370.6**

**-Бусад тогтмол зардал:3,585.7**

Эрчим хүчний сайдын 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/126 дугаар тушаалаар Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон баталж, тайлант оны нийт орлогыг 25,257.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 27,949.7 сая төгрөгөөр нийт 2,691.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 26,384.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 28,372.5 сая төгрөгийн зардал гарган 1,988.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 26,384.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,126.5 сая төгрөг буюу 4.5 хувиар давуулан биелүүлсэн. Үүнд цахилгаан эрчим хүчний түгээлтийг 136.6 сая.квтц буюу төлөвлөгөөнөөс 4.4 сая.квтц-аар, дулааны эрчим хүчийг 241.1 мян.Гкал буюу төлөвлөгөөнөөс 19.0 мян.Гкал-аар илүү түгээсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Мөн ЭХЗХ-ны 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 670 дугаар тогтоолоор 2022 оны 12 дугаар сард Диспетчерийн үндэсний төв ХХК-д худалдах цахилгааны чадлын тарифыг 1,078.6 сая төг/сар, цахилгааны энергийн тарифыг 104.97 төг/кВт.ц болгож нэмэгдүүлэн баталсан нь нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 28,372.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 422.8 сая төгрөг буюу 1.5 хувиар хэтэрсэн байна. Үүнд түлшний зардал 635.4 сая төгрөгөөр, урсгал засварын зардал 113.1 сая төгрөгөөр, хөдөлмөр хамгааллын зардал 44.9 сая төгрөгөөр, үйл ажиллагааны бус зардал 100.1 сая төгрөгөөр тус бүр хэтэрч, байгаль орчин хамгаалах зардлыг 64.2 сая төгрөгөөр, усны нөөц ашигласны төлбөрийг 122.1 сая төгрөгөөр, ажиллагсдын нийгмийн зардлыг 286.5 сая төгрөгөөр тус бүр хэмнэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Нийт зардлын гүйцэтгэлд түлшний зардал 39 хувь, цалин нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 34 хувь, бусад тогтмол зардал 13 хувь, элэгдлийн зардал 13 хувь, үйл ажиллагааны бус зардал 1 хувийг тус бүр эзэлж байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 37 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 2,032.6 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 1,988.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 703.7 сая төгрөгөөр буурсан нь нийт орлогыг төлөвлөснөөс 1,126.5 сая төгрөгөөр давуулан биелүүлж, нийт зардал 422.8 сая төгрөгөөр хэтэрсэн нь нөлөөлж байна.

**Нийт зардлын талаар:**

Сая төгрөгөөр

| Үзүүлэлтүүд                   | 2021 он  | 2022 он  |          | зөрүү   |         |
|-------------------------------|----------|----------|----------|---------|---------|
|                               |          | төл      | гүйц     | өн.он-с | төл-с   |
| 1. Үйлдвэрлэлийн зардал       | 26,029.0 | 27,785.2 | 28,107.8 | 2,078.8 | 322.6   |
| Түлшний зардал                | 10,238.9 | 10,381.6 | 11,017.1 | 778.2   | 635.5   |
| Цалин, НДШ-ийн зардал         | 8,874.3  | 9,626.7  | 9,624.8  | 750.5   | (1.9)   |
| Элэгдлийн зардал              | 3,534.1  | 3,657.6  | 3,812.0  | 277.9   | 154.4   |
| Бусад тогтмол зардал          | 3,381.7  | 4,119.3  | 3,653.9  | 272.2   | (465.4) |
| 2. Үйл ажиллагааны бус зардал | 218.9    | 164.5    | 264.7    | 45.8    | 100.2   |
| Нийт зардлын дүн              | 26,247.9 | 27,949.7 | 28,372.5 | 2,124.6 | 422.8   |

**2022 оны БОШХ дараах байдлаар батлагдсан.**

Сая төгрөгөөр

| Үзүүлэлтүүд              | БОШХ      | Гүйцэтгэл | Зөрүү    |
|--------------------------|-----------|-----------|----------|
| Түлшний зардал           | 11,135.80 | 11,017.10 | (118.70) |
| Цалин, шимтгэлийн зардал | 8,383.00  | 9,624.80  | 1,241.80 |
| Элэгдлийн зардал         | 2,370.60  | 3,812.00  | 1,441.40 |
| Бусад тогтмол зардал     | 3,585.70  | 3,918.60  | 332.90   |
| Нийт                     | 25,475.10 | 28,372.50 | 2,897.40 |

**Нийт авлагыг 3,288.8 сая төгрөгөөс, богино хугацаат өр төлбөрийг 2,636.2 сая төгрөгөөс бууруулах, санхүүгийн зохистой харьцаа/эргэлтийн/-г 1.1-ээс дээш түвшинд хангаж ажиллах.**

**Эдийн засгийн үзүүлэлтүүд: Авлага, өглөг**

| Авлагын төрөл      | 2021 оны<br>гүйцэтгэл<br>сая.төг | 2022<br>оны төл<br>сая.төг | 2022 оны<br>гүйцэтгэл<br>сая.төг | Өөрчлөлт        |             |
|--------------------|----------------------------------|----------------------------|----------------------------------|-----------------|-------------|
|                    |                                  |                            |                                  | өн.оноос        | төл-с       |
| ДҮТ ХХК            | 2,812.3                          | 1,640.0                    | 1,471.8                          | -1,340.5        | -168.2      |
| УБДС ХК            | -                                | -                          | -                                | -               | -           |
| Бусад авлага       | 476.5                            | 50.0                       | 213.2                            | -263.3          | 163.2       |
| <b>Нийт авлага</b> | <b>3,288.8</b>                   | <b>1,690.0</b>             | <b>1,685.0</b>                   | <b>-1,603.8</b> | <b>-5.0</b> |

КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

Нийт авлага 1,685.0 сая төгрөг, үүнээс “ДҮТ” ХК-иас авах авлагын үлдэгдэл 1,471.8 сая төгрөг болж оны эхнээс 1,603.8 сая төгрөгөөр, төлөвлөгөөнөөс 5.0 сая төгрөгөөр бууруулан ажилласан байна.

| Өглөгийн төрөл               | 2022 оны<br>төл<br>сая.төг | 2021 оны<br>гүйцэтгэл | 2022 оны<br>гүйцэтгэл | Өөрчлөлт        |               |
|------------------------------|----------------------------|-----------------------|-----------------------|-----------------|---------------|
|                              |                            | сая.төг               | сая.төг               | Он<br>оноос     | Төл-с         |
| Багануур ХК                  | -                          | 629.6                 | 83.4                  | -546.2          | -             |
| Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг  | -                          | 1,622.8               | 827.3                 | -795.5          | -             |
| Татварын өглөг               | -                          | 383.8                 | -                     | -383.8          | -             |
| <b>БХӨТ-ийн дүн</b>          | <b>1,300.0</b>             | <b>2,636.2</b>        | <b>910.7</b>          | <b>-1,725.5</b> | <b>-389.3</b> |
| УХЗээл, зээлийн хүү          | 397.5                      | 439.4                 | 397.5                 | -41.9           | -             |
| <b>Нийт өр төлбөрийн дүн</b> | <b>1,697.5</b>             | <b>3,075.6</b>        | <b>1,308.2</b>        | <b>-1,767.4</b> | <b>-389.3</b> |

Нийт өглөг 1,308.2 сая төгрөг, үүнээс богино хугацаат өглөг 910.7 сая төгрөг болж оны эхнээс 1,767.4 сая төгрөгөөр, төлөвлөгөөнөөс 389.3 сая төгрөгөөр бууруулан ажилласан байна. Тайлант хугацаанд татварын өр төлбөр үүсгэхгүй ажилласан.

Дамжуулан зээлдүүлэх төслийн зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг графикийн дагуу БХӨТ-рүү бичсэн.

Компанийн санхүүгийн эргэлтийн харьцаа:

Эргэлтийн харьцаа =  $3,396.6 \text{ сая төгрөг} / 910.7 \text{ сая төгрөг} = 3.7$  байна.

Энэ  $3.7 > 1.1$  нь зохистой хэмжээнд байна.